



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

БУЛГАН АЙМГИЙН БУГАТ СУМЫН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Аудитын код: БУА-2026/39/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Булган аймаг

2026 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Д.Батцогт

Утас: 70342716 Цахим хаяг: Battsogtd@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Намчинсүрэн

Утас: 70342716 Цахим хаяг: Namchinsureng@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт	4
Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд.....	6
Гурав. Аудитын илрүүлэлт:	7
Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	8

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ЗДТГ	Засаг даргын тамгын газар

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2026-02-24 № 277
танай _____ ны № _____ Т

БУГАТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Х.ХАЛИУНБАТ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бугат сумын ЗДТГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитын асуудалтай холбоотой нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 24.6 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 7.7 сая төгрөгөөр давсан ба материаллаг алдаа, зөрчил нь тархаагүй тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө. Үүнд:

- Албан хаагчдад ажилласан хугацааны нэмэгдэл 0.4 сая төгрөгийн цалин илүү тооцоолон олгосон;
- Шатахууны зардлаас 0.6 сая төгрөгийг анхан шатны баримтгүй зарцуулсан;
- Төрийн албан хаагчийн эзгүй орон тоог (жигжиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн, бэлчээр газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн) түр орлон гүйцэтгэсэний нэмэгдэл цалин 1.0 сая төгрөгийг илүү тооцон олгосон;
- Засаг даргын нөөц хөрөнгөөс тэргүүний ахмадын баяр тэмдэглэн

6326050395

- өнгөрүүлэхэд зориулан 6.5 сая төгрөгийг зарцуулсан;
- Засаг даргын нөөц хөрөнгөөс 8.5 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зориулалт бус зарцуулсан;
 - Засаг даргын нөөц хөрөнгөөс тэмцээн уралдаан зохион байгуулахад зориулан нийт 6.5 сая төгрөгийг зарцуулсан;
 - Хойд бүсийн спортын наадамд 1.0 сая төгрөгийг бэлэн мөнгөөр няравын хувийн дансанд шилжүүлж зарцуулахдаа анхан шатны баримтгүй зарцуулсан;
 - Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин цагаан сарын мэндчилгээний зардалд 1.0 сая төгрөгийг зарцуулсан зэрэг зөрчлүүд нь Төрийн аудитын тухай хуулийн 42.1, 42.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6, 20.1.2, 20.2.4, 20.2.5, Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.5, Засгийн газрын 2019 оны "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам", Сангийн сайдын Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн баталсан байна. Үүнтэй холбоотойгоор цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардал өмнөх оноос 20,0 хувиар өссөн байна.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн нөлөөтэй асуудлыг үздэг.

Аудитын явцад санхүүгийн тайланг бүхэлд нь хамарсан адитын агуулгын хүрээнд дүгнэлт гаргахад нөлөөлсөн асуудлыг санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурьдсан болно.

Бусад асуудал

Тус байгууллага нь 2025 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 28 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 94.2 хувьтай үнэлүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31.
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	90,682.0	94,287.6
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,753,109.6	3,136,706.8
Нийт хөрөнгийн дүн	2,843,791.6	3,230,994.4
Нийт өр төлбөрийн дүн	-	1,952.2
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,843,791.6	3,229,042.2
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,843,791.6	3,230,994.4
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	1,187,495.3	1,764,745.7
Үйл ажиллагааны зардлын дүн	1,505,167.2	1,378,153.4
Үйл ажиллагааны үр дүн	(317,671.9)	386,592.3
Үйл ажиллагааны бус үр дүн	1,750.0	1,341.7
Үйл ажиллагааны нийт үр дүн	(319,421.9)	385,250.6
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,384,350.0	2,843,791.6
Тайлант оны үр дүн	459,441.6	385,250.6
Эцсийн үлдэгдэл	2,843,791.6	3,229,042.2
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,187,215.3	1,241,394.1
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,173,975.3	1,241,402.9
Үйл ажиллагааны ЦМГ	13,240.0	(8.8)
Хөрөнгө оруулалтын ЦМГ	(14,130.0)	-
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	(890.0)	(8.8)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	8.8
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,083,924.50	1,025,542.0
Урсгал зардал	1,083,924.5	1,025,542.0
Хөрөнгийн зардал	-	-
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	1,083,924.5	1,025,542.0
Орон нутгийн төсвөөс	1,083,924.5	1,025,542.0
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	-

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 50.0 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс 4.2 сая төгрөгийн 5 төлбөрийн акт тогтоож, 15.0 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 25.3 сая төгрөгийн 2 зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн зөрчлөөс санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой 24.6 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 2.1 сая төгрөгөөр их тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

5.1 Төлөрийн акт

1. Төрийн албан хаагчийн сул орон тоог түр орлон гүйцэтгэсэний цалинг 1.5 сая төгрөгөөр илүү тооцон олгосон нь Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.5, Засгийн газрын 2019 оны "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам", санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

2. Төсвийн хөрөнгөөр бэлэг дусгалын зүйл худалдан авахад нийт 0.5 сая төгрөгийг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

5.2 Албан шаардлага

1. Өмнөх оны аудитын шийдэрийн хэрэгжилтийг бүрэн биелүүлээгүй нь санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй зөрчилд зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

2. Засаг даргын нөөц хөрөнгөөс 8.5 сая төгрөгийн хөрөнгийг /ланд-200 маркийн авто машины өвлийн дугуй -1.9, ёслол хүндэтгэлийн өргөө буюу гэрлэх ёслолын ордоны суурь цутгах-6.6/ худалдан авах, ажил гүйцэтгэхэд зориулалт бус зарцуулсан, орлогод авч бүртгэлжүүлээгүй нь санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй зөрчилд зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

3. Засаг даргын нөөц хөрөнгөөс тэмцээн уралдаан зохион байгуулахад зориулан нийт 6.5 сая төгрөгийг зарцуулсан нь санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй зөрчилд зөрчлийн таслан зогсоох дахин давтахгүй байх албан шаардлагыг хүргүүлээ.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардал данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Засаг даргын нөөц хөрөнгөөс тэргүүний ахмадын баяр тэмдэглэн өнгөрүүлэхэд зориулан 6.4 сая төгрөгийг зарцуулсан нь санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмыг бүрэн хэрэгжүүлэх, жил бүр гардаг буюу төлөвлөх боломжтой зардлыг ЗДНХ-өөс санхүүжүүлэхгүй байх.

1. Зардал данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Шууд худалдан авалтаар гэрээ байгуулан худалдан авах барааны техникийн тодорхойлолтод шаардлагатай гэж үзсэн түүхий эд, материал болон шалгуур үзүүлэлтийг бүрэн тодорхойлоогүй байгаа нь санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн олон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Албан хаагчид ажилласан хугацааны нэмэгдэл цалин илүү тооцоолон олгосон	1	0.5	1.0	0.5								
Шатахууны зардлын анхан шатны баримтын бүрдэл дутуу	1	0.6	1.0	0.6								
Төрийн албан хаагчийн эзгүй орон тоог /жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн, бэлчээр газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн/ түр орлон гүйцэтгэсэний цалинг илүү тооцон олгосон	1	1.1	1.0	1.1								
Засаг даргын нөөц хөрөнгөөс тэргүүний ахмадын баяр тэмдэглэн өнгөрүүлэхэд	1	6.4					1	6.4				

зориулан 6.4 сая төгрөгийг зарцуулсан												
Засаг даргын нөөц хөрөнгөөс 8.5 сая төгрөгийн хөрөнгийг /ланд-200 маркийн авто машины өвлийн дугуй -1.9, ёслол хүндэтгэлийн өргөө буюу гэрлэх ёслолын ордоны суурь цутгах-6.6/ худалдан авах, ажил гүйцэтгэхэд зориулалт бус зарцуулсан	1	8.6			1.0	8.6						
Засаг даргын нөөц хөрөнгөөс тэмцээн уралдаан зохион байгуулахад зориулан нийт 6.5 сая төгрөгийг зарцуулсан	1	6.5			1.0	6.5						
Хойд бүсийн спортын наадамд 1.0 сая төгрөгийг бэлэн мөнгөөр няравын хувийн дансанд шилжүүлж зарцуулахдаа анхан шатны баримт болох зардлын төсөв байхгүй, юунд хэрэхэн зарцуулсан баримт огт байхгүй	1	1.0	1.0	1.00								
Дүн	7	24.6	4.0	3.15	2.0	15.1	1	6.4	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн	0	0	0	0	0	0.0	0	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил /төрийн хэмнэлтийн тухай хууль/								
Өмнөх оны аудитын шийдэрийн хэрэгжилтийг бүрэн биелүүлээгүй	1	5.54			1	5.54		
Шууд худалдан авалтаар гэрээ байгуулан худалдан авах барааны техникийн тодорхойлолтод шаардлагатай гэж үзсэн түүхий эд, материал болон шалгуур үзүүлэлтийг бүрэн тодорхойлоогүй	1	18.9			0	-	1	18.9
Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин цагаан сарын мэндчилгээний зардалд 1.0 сая төгрөгийг зарцуулсан	1	1.0			1	1.0		
Дүн	3	25.4	1	1.0	1	5.5	1	18.9
Нийт дүн	3	25.4	1	1.0	1.0	5.54	1	18.9

